



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 02

Арвайхээр

Дүгнэлт гаргах тухай

Гомдлыг хянан шалгах комиссын дүгнэлтийг хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч хянан шийдвэрлэх журам"-ын "Гурав"-ын 15, 16 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. 3.Дагвасүрэнд албан үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж үзэж урьд нь холбогдох хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулсан эрх зүйн акт гараагүй байх тул Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтыг үндэслэсэн нь буруу гэж тогтоосугай.

2. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7 дахь заалтуудыг зөрчснөө 3.Дагвасүрэн нь өөрөө хүлээн зөвшөөрч Санхүүгийн хяналт, аудитын албаны улсын байцаагчийн 2017 оны 29/01 тоот дүгнэлт, "Зориулалт бус зарцуулсан хөрөнгийг нөхөн төлүүлэх тухай" Санхүүгийн хяналт, аудитын албаны улсын байцаагчийн 2017 оны 03 тоот актад гарын үсэг зурсан байх тул Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалтыг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулсан нь үндэслэлтэй гэж үзсүгэй.

3. Уянга сумын Засаг даргын "3.Дагвасүрэнг ажлаас халах тухай" 2017 оны б/02 дугаар захирамжийн үндэслэл хэсэгт Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалтуудыг давхардуулан хэрэглэсэн нь буруу байх тул зохих журамд нийцүүлэхийг Уянга сумын Засаг дарга /Б.Доржтогоо/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

03 0003

D:My Doc.togtool TAZ